

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠠᠤᠳᠢᠲᠢᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫНТАЙЛАН**

АУДИТЫН КОД: СУА-2025/113-ШТА-НА

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
БҮЛЭГ 1. НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХЭСГИЙН ХОРООНЫ	
ТООТОЙ УЯЛДУУЛАН, ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛЖЭЭ.	4
1.1. Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэлийн ерөнхий газраас	
сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль, журмын	
дагуу хуваарилсан байна.	4
БҮЛЭГ 2. НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН	
ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ	
ЗАРЦУУЛЖЭЭ.	4
2.2. Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан	
төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.	4
3. ДҮГНЭЛТ:	5
4. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	6

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг дагуу хийв.
Аудитын зорилт	Орон нутгийн 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: - Орон нутгийн нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх - Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн газрыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Золзаяа, аудитор Г.Оюунболд, О.Барчидгүнсэн, Б.Мөнхбамбар, нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХЭСГИЙН ХОРООНЫ ТООТОЙ УЯЛДУУЛАН, ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛЖЭЭ.

1.1. Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль, журмын дагуу хуваарилсан байна.

1.1.1 Нөхөн сонгуулийг зохион байгуулах зардлыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1 дэх заалт болон Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусган, улсын төсвөөс санхүүжүүлсэн. Энэхүү зохицуулалтын хүрээнд аймгийн сонгуулийн хороо болон хэсгийн хорооны тоо, ажиллах албан хаагчийн тоонд үндэслэн 39.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод санал авах байр бэлтгэх, шуудан холбоо, бичиг хэрэг, унааны зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан журмын 1-р хавсралтын 2.3 дахь заалт болон Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн зааварчилгааны дагуу төсөв хуваарилсан байна.

1.1.3. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2¹-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Улсын бүртгэлийн газарт 2.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

БҮЛЭГ 2. НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.

2.2. Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2.2.1. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 39.6 сая төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэлээр 38.8 сая төгрөгийг зарцуулж, 0.8 сая (аймгийн сонгуулийн хороо 0.8 сая) төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт төвлөрүүлсэн байна.

2.2.2. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор санал авах байр тохижуулах зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд цаашид ашиглах боломжтой материалыг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байна.

2.2.3. УБЕГ-ын даргын 2025 оны А/82 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 2.3 сая төгрөгийг төсөв хуваарилжээ. Үүнээс мөнгөн урамшуулалд 1.7 сая, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн зардалд 0.6 сая, техник хэрэгсэл тээвэрлэх турших болон шуурхай багийн зардал 0.04 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

2.2.4. Аймгийн сонгуулийн хороонд 39.6 сая төгрөгийн санхүүжилт хуваарилснаас 38.8 сая төгрөгийг дараах 11 төрлийн зардалд зарцуулсан байна. Нийт зардлын

¹ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

60.4 хувь буюу 23.9 сая төгрөгийг сонгуулийн хорооны ажилчдын урамшуулал болон хоолны зардалд, 12.1 хувь буюу 4.8 сая төгрөгийг унааны зардалд, 12.1 хувь буюу 4.8 сая төгрөгийг саналын хуудас, төхөөрөмжийг авах, хүргэх зардалд, 15.4 хувь буюу 5.3 сая төгрөгийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

2.2.5 Сонгууль зохион байгуулахтай холбоотой гарсан зардлын гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв тайлагнаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт№1

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	0.1	0.1	-
2	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	0.3	0.3	-
3	Сургалтын зардал	1.4	1.4	-
4	Сурталчилгааны зардал	0.7	0.69	0.01
5	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал, НДШ-АО	23.9	23.9	-
6	Бичиг хэргийн зардал	0.5	0.5	-
7	Шуудан холбооны зардал	0.7	0.7	-
8	Унааны зардал	4.8	4.8	-
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	0.5	0.5	-
10	Саналын хуудас, төхөөрөмжийг авах, хүргэх зардал	4.8	4.8	-
11	Шуурхай багийн зардал	1.7	1.1	0.6
12	Эрчим хүчний эх үүсгэвэр ашиглах зардал	0.14	-	0.14
Дүн		39.54	38.79	0.75

3. ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг холбогдох маягтын дагуу тайлагнаж хэвшсэн байна.

4. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



СҮХБААТАР АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

201 тоот, 2 давхарт, Нутгийн удирдлагын ордон, 7
дугаар баг, Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075

Утас: 70512024

Цахим шуудан: ssonguuliinhoroo@gmail.com

2025.07.22 № 56

танай _____-НЫ _____-Т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн
зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцалаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал
байхгүй болно.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Холбогдох байгууллагаас ирсэн саналд тайлбар байхгүй.